



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 1301

Улаанбаатар хот

Олон улсын Багш нарын өдрийг тохиолдуулан
дүүргийн багш нарт хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Чингэлтэйн боловсрол-2028" арга хэмжээ батлах тухай 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Олон улсын Багш нарын өдөр"-ийг тохиолдуулан дүүргийн багш нарт хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Ж.Тамир	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Т.Батцэцэг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Г.Энхбаяр	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ц.Цолмонбаатар	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	Ш.Оюунсүрэн	Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн захирал
	С.Сэлэнгэ	Дүүргийн 37 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
Нарийн бичгийн дарга:		
	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

2.Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар ханган, хэрэгжилтэд анхаарч, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

3.Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010881

D:\2025 он\2025\Zahiramj\zahiramj 2025.docx